МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 11 өдөр Дугаар А/472 Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол "Журам батлах тухай", Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаал "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай", аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан Герман Улсын Барут марк хоттой гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээний хүрээнд Герман улсад музейн зориулалтаар барих гэр бэлтгэх төсөл арга хэмжээний нийлүүлэгч сонгох ХӨАОНӨГ/202307183 дугаартай тендерт 47,900,000 (Дөчин долоон сая есөн зуун мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Амарбаян" хоршооны тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Амарбаян" хоршоотой гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Гадаад харилцааны бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн (Д.Цэнд-Аюуш)-ийг томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцааны бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)
Ажлын хэсгийн гишүүд: Т.Мягмарсүрэн (Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын иргэдийн Төлөөлөгчийн хурлын дарга)
Н.Гэрэлчулуун ("Амарбаян" хоршооны захирал)
А.Энхжаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргаа байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

3. Герман Улсын Барут марк хоттой гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээний хүрээнд Герман улсад музейн зориулалтаар барих гэр бэлтгэх төсөл арга хэмжээний бараа нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, бараг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх,

d/A4

671011016

санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивт шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Д.Цэнд-Аюуш)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн өмчийн газрын архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ